



УЛААНБААТАР ХОТЫН  
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН  
ТУШААЛ

2020 оны 01 сарын 03 өдөр

Дугаар А/04

Улаанбаатар хот


Зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай

Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйл, 21 дүгээр зүйлийн 21.3, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/1358 дугаар захирамж, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 1 дүгээр хэсгийн 1.3, 2 дугаар хэсгийн 2.2, 3 дугаар хэсгийн 3.1.2, 4 дүгээр хэсгийн 4.3.1, 4.3.3, 4.3.7-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Шинэ бүтээн байгуулалт хөтөлбөрийн хүрээнд Хөгжлийн банкны санхүүжилтээр баригдсан, нийслэлийн өмчид бүртгэлтэй Хан-Уул дүүргийн 10, 16 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах "Буянт-Ухаа 1, 2" хорооллын инженерийн шугам сүлжээ, ус дулаан дамжуулах төвийн ашиглалт, засвар үйлчилгээг Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар ОНӨААТҮГ-т шилжүүлэх, инженерийн шугам сүлжээ, барилга байгууламжийг 2020 оны 01 дүгээр сарын 15-ны дотор бүртгэлжүүлэн хүлээлгэн өгөх үүрэг бүхий Ажлын хэсгийг хавсралт ёсоор байгуулсугай.

2. Бүртгэлээр хүлээн авсан шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн горим тохируулгыг хийж, хэрэглэгчдийг ус, дулаанаар тасралтгүй хангах удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар ОНӨААТҮГ /Ч.Мэндбаяр/-т даалгасугай.

3. Төрийн орон сууцны корпораци ХХК-аас шилжин ирэхээр төлөвлөж буй дээрх хорооллын ус дулаан дамжуулах төвийн өргөтгөлийн эд хөрөнгийг Нийслэлийн өмчид бүртгүүлэх, ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөх ажлыг 2020 оны 1 дүгээр сард багтаан зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Ажлын хэсэг /Ц.Рэгзэдмаа/-т үүрэг болгосугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР  
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА  Т.ГАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн  
2010...оны...сарын...-ны өдрийн  
тушаалын хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:	Ц.Рэгзэдмаа	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Дотоод хяналтын хэлтсийн дарга
Гишүүд:	С.Даваасүрэн	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын дэд дарга
	М.Энхболд	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
	В.Даваадорж	Нийслэлийн Цагдаагийн удирдах газрын Хэв журмын хэлтсийн Эргүүл хамгаалалтын тасгийн дарга
	С.Батмөнх	Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар" ОНӨААТҮГ-ын Инженерийн байгууламж хариуцсан дэд дарга бөгөөд ерөнхий инженер
	Л.Алтангэрэл	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын инженерийн байгууламжийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
	Э.Уянга	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтсийн Хууль, эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн
	П.Алтанхуяг	Нийслэлийн Орон сууцны корпораци ХК-ийн Орон сууцны ашиглалт, борлуулалтын хэлтсийн дарга
	Т.Заяа	Төрийн орон сууцны корпораци ХХК-ийн дэд захирал /зөвшилцсөнөөр/
С.Ерөөлт	Төрийн орон сууцны корпораци ХХК-ийн ерөнхий нягтлан бодогч	
Нарийн бичгийн дарга:	Б.Энхжаргал	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын инженерийн байгууламжийн хэлтсийн мэргэжилтэн
	Т.Ганчимэг	Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар" ОНӨААТҮГ-ын Инженерийн бодлого, хяналтын хэлтсийн дарга